



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/589

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 27 дугаар зүйлийн 271.2, 32 дугаар зүйлийн 32.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн ахмад настны асрамж үйлчилгээний төвийн асруулагчдын байрлаж буй аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ахмадын сувиллын байранд объектын гал түймэр гарч асруулагчид байрлах боломжгүй болсон тус байранд засвар, үйлчилгээ, ариутгал, үнэлгээ хийх, асруулагчдыг нэн даруй буцааж байрлуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Цэцэгмаа- аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: М.Үүрийнбаяр- аймгийн Эрүүл мэндийн газрын дарга

Н.Шинэбаяр- аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын Барилгын хэлтсийн даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

А.Баянхангай- аймгийн Онцгой байдлын газрын мэргэжилтэн, ахмад
П.Санлигрэнчин-“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн гүйцэтгэх
захирал

Г.Даваадорж- “Хөвсгөл Эрчим Хүч” ХХК-ийн ерөнхий инженер


Д.Сүхээ- “Хөвсгөл Ус суваг” ХХК-ийн ерөнхий инженер

Нарийн бичгийн дарга: Т.Раднаабүд- аймгийн Хөдөлмөр, халамжийн
үйлчилгээний газрын дарга

2. Арга хэмжээг шуурхай зохион байгуулж, тайлагнахыг ажлын хэсэг
(Д.Цэцэгмаа)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын
Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ